



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 05 дугаар сарын 12 өдөр

Дугаар 34

Хэрлэн сум

XXXIV ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын XXXIV хурал 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 94 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1.Мэргэжлийн болон танхимын сургалт, спорт заалныг ашиглах асуудлыг хэрхэн зохион байгуулах тухай:

Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа

2.МостАзи ХХК-аас аймгийн Автотээврийн төвд ирүүлсэн газрын тос тээвэрлэлтийг гүйцэтгүүлэх 4 тээврийн хэрэгслийн жолоочийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх хүсэлтийг танилцуулах:

Автотээврийн төвийн дарга Ц.Мөнхтөр

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн А.Нансалмаа нарт:


1.1.Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газраас коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан зөвлөмж, шаардлагыг хангасан, зохих зөвшөөрөл бүхий сургалтын төвийн танхимын сургалтыг үе шаттай эхлүүлэх, нэг танхимд 10-аас дээшгүй хүнтэйгээр, танхимын сургалтад 16-аас доош насны хүүхдийг хамруулахгүйгээр зохион байгуулахыг зөвшөөрөв,


Хоёр. Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
орлогч дарга Ч.Ганбат-д

2.1. Энэхүү хурлын шийдвэрийн 1.1. дахь заалтын дагуу захирамжийн төсөл боловсруулж аймгийн Засаг даргад танилцуулахыг,

Гурав. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,
Автотээврийн төвийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Мөнхтөр нарт:

3.1. МостАзи ХХК-аас аймгийн Автотээврийн төвд ирүүлсэн газрын тос тээвэрлэлтийг гүйцэтгүүлэх 4 тээврийн хэрэгслийн жолоочийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА